

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн!

АНХ ДЭГТААР ТАВАН ЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ № 55 (2319) 1974 оны 7 дугаар сарын 22 ДАВАА

ОНООС ТҮРҮҮЛЭГСЭД

Борнуурын САА-н хоньчин Батаа, Баян Өнжүүл сумын хоньчин, БНМАУ-ын хөдөлмөрийн баатар Б. Ажваагийн туршлагаар ажиллаж нийт хонины жинг 54 тоннор нэмэгдүүлэн 3 жилд 5 жил 3 сарын ажил хийжээ. Мөн САА-н тракторчин Даваахүү 3 жилд 356,3 зөөлөл га-гийн ажил хийж 6 жил 7 сарын ажил гүйцэтгэсэн байна.

Аймгийн хошой аварга, 74 настай эмгэн Дэжид нутгийн үүдлрийн 12 үнээнээс 46600 гаруй литр сүү сааж 5 жил 3 сарын ажил хийгээд бүх эрд түмний социалист уралдаанд хамт олноо хошуучилж явна.

Ч. РАГЧАА

ӨРГӨН АЙЛСАЛТ

Өргөн айлсалтад өгс тэжээл бэлтгэх өвлийн бэлтгэлээ хангах, рашаан сувилал, эмчилгээ амралтанд явах, сургуульд хүүхдээ бэлтгэх, ан агнах, гэр орноо засч сэлбэх, хувцас хунараа оёх зэрэг олон талт хамтач ажил явагдана. Суурь, малчдын хүчин дээд хүрэлцээгүйн улмаас ар гэртээ татагдан, мал оторлолтын чанар суларч зарим зорилт нь биелэхгүй таардаг явдлыг өргөн айлсалт арилгадаг юм.

Мөн нэгдлийн үйлдвэрлэл, хөдөлмөр зохион байгуулалтыг тодорхой болгож, хөдөлмөрийн бүтээмжийг өндөржүүлж, ажиллах хүчний хүрэлцээг сайжруулснаар өргөн айлсалт чухал ач холбогдолтой билээ.

Иймээс өргөн айлсалт нь хамтарч сурч соёлжих социалист уралдааны амлалт үүргээ биелүүлэхэд дөхөм үзүүлдэг нэгдэлч малчдын хамтын ажиллагааны тохиромжтой хэлбэр, мөн малчид өргөн айлсалтанд буусан даруй хамт олноороо хэлэлцэн өргөн айлсалтын зөвлөлийг сонгож, тэдэнд дарга, хүмүүжлийн ажлын багш, ариун цэвэр, хүүхэд эмэгтэйчүүдийн секц, тоо бүртгэгч гэх зэргээр ажлыг хуваарилан өгч хариуцуулах ёстой.

Зөвлөлийн дарга нь өргөн айлсалтад зохиогдох үйлдвэрлэл хамтын хөдөлмөр, соёл хүмүүжлийн бүхий л ажилд зөвлөлийн гишүүд, хөдөлмөрчдийг зохион байгуулж удирдах үүрэгтэй. Соёл хүмүүжлийн ажил эрхэлсэн багш нь хэлбичиг, тооны (суурийн сургуулийн) хичээл заах, урлаг уран сайхны ажлыг удирдаж зоо-мал эмнэлгийн анхны мэдэгдэхүүнийг малчид, хөдөлмөрчдөд эзэмшүүлэх, ариун цэвэр, хүүхэд эмэгтэйчүүдийн секц нь орчин тойрон гэр орон хүмүүсийн ариун цэврийг сайжруулах, ахуйн соёлыг дээшлүүлэх, хүүхдийн дунд хүмүүжлийн ажил зохиох гэрийн цэцэрлэг байгуулах зэрэг хүүхдийн хүсэл сонирхол аятай тохитой байдалд нь тохирсон ажлыг санаачлан зохиох үүрэг хүлээнэ.

Өргөн айлсалтын зөвлөл нь ажлаа нарийн төлөвлөж, түүний явцыг удирдах байгууллага, хамт олоноо байнга мэдэгдэж ажлын тайлангаа тавьж хэлэлцүүлдэг байвал зохино.

Айлсалтын үеэр малын тэжээл бэлтгэхэд хүн бүрт чадал хүчинд нь тохирсон ноогдол үүрэг өгч гүйцэтгүүлэх хэрэгтэй. Түүнчлэн цөөн тооны үнээ гүү сааж цагаан идээ боловсруулах цөцгий тос хийх, ширээс ширэх, дээс томох, хана үдэх, дээл хувцас хийх зэрэг ажлыг хамтарч гүйцэтгэнэ.

Өргөн айлсалтын хамт олон нь нийгмийн үйлдвэрлэлийн хөдөлмөрийн явцад харилцан арга туршлагаа солилцож бие биенээсээ байнга суралцах эрмэлзэлтэй ажиллах нь зүйтэй.

Сумын нам, захиргаа, олон нийтийн байгууллагаас өргөн айлсалтад үйлчлэн сурталчлах ухуулга урлагын бригадыг гарган тэдэнд цаг үеийн чухал сэдвээр ухуулга яриа хийж, самбар үзүүлэн кино диафильм үзүүж мал ажиллагааны давшилттай аргуудыг сурталчилж байвал зохино.

Өргөн айлсалтыг өөрийн сумын онцлог байдалд тохируулан чадварлаг зохион байгуулах явдал нийт сумдын нам, улс, олон нийт, ХАА-н байгууллагуудын чухал зорилт болж байна.

ХАДЛАНГИЙН

МАА-г тогтвортой өсгөж ашиг шинжийг нь байнга нэмэгдүүлэн малын зүй бусын хорогдлыг багасгахад түүний тэжээлийн баазыг байнга бэхжүүлэх нь чухал ач холбогдолтой билээ.

Энэ онд улсын хэмжээгээр 804 мянган тонн байгалийн хадлан, 76,5 мянган тонн ногоон тэжээл, 92,3 мянган тонн шүүст тэжээл, аймгийн хэмжээгээр 95,7 мянган тонн байгалийн хадлан, 74,1 мянган тонн таримал тэжээл бэлтгэх юм.

1974 оны ургац хураах хадлан авах арга хэмжээний тухай МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөл чухал тогтоол гаргав.

МАХН-ын III их хурал хуралдсаны болон БНМ АУ-ыг тунхагласны 50 жилийн ой, Атар газар эзэмшсэний 15 жилийн ойг угтаж ургац хураах, хадлан авах ажлыг богино хугацаанд чанартай хийж улсад тушаах үр тариа, төмс, хүнсний ногоо, хадлан өвсний төлөвлөгөөг давуулан биелүүлэх зорилтыг нам, засгаас дэвшүүлэв.

Тус аймгийн САА, ХАА-н нэгдлүүдэд хадлангийн механикжсан бригад, салаа 5, трактор хадуур 14, морин хадуур 40, өвс сүрэл боох утас 300 гаруй тонныг улсаас хуваарилав. Аймаг, сумдын нам, улс, олон нийт, ХАА-н байгууллагууд халлан тэжээл бэлтгэх түүний бэлтгэлийг хангах талаар багагүй ажил зохиож хадлангийн га тутмын ургацыг нэмэгдүүлэх зорилгоор 200 га талбай устгаж бордон Өндөрширээт, Баянцогт, Угтаал зэрэг сумдад 7,0 мянга гаруй га талбай цэвэр-

АЖИЛ-БҮХ НИЙТИЙН ХЭРЭГ

лэж 200 гаруй морьдыг сургаж, хадланчдын соёл ахуйн бэлтгэлийг хангах иргэдийн хүчээр бэлтгэх өвсний даалгаврын хуудсыг 15,4 мянган хүнд гардуулан 5,0 мянга орчим тонн өвс бэлтгүүлэх даалгавар өгсний гадна хадланд ажиллах техник ХАА-н машин багажийг бүрэн засварлаж сэлбэх хэрэгсэл, шатах тослох материалыг татаж аймгийн хэмжээгээр хадлангийн техникийн засварыг 6 дугаар сарын 25-нд дуусгав. Жаргалант, Баянцогт, Баян-өнжүүд, Бүрэн, Мөнгөнморьт, Заамар, Алтанбулаг сумд хадлангийн бэлтгэлийг бусад сумдаас давуутай сайн хангажээ.

Гэвч энэ зун цаг сайхан, олоодоо ургац тагчир, хадланд гарах цаг болоогүй гэж тайвшрах, хадлан тэжээл бэлтгэх бэлтгэл зарим газарт хангалтгүй байгаа зэрэгт нам, улс, олон нийт, ХАА-н бүх байгууллагууд дүнэлт хийж хадлан тэжээл бэлтгэх ажлын эрч далайцыг улам нэмэгдүүлэх зорилт тавигдаж байна.

Хадлан тэжээл бэлтгэх зорилтыг биелүүлэхдээ нам, улсын байгууллага, нэгдэл, САА-н удирдах ажилташ, мэргэжилтнүүд тэжээл бэлтгэх бүх ажлыг цаг тухайд нь хангаж үлгэр жишээчээр төлөвлөгөөг биелүүлбэл зохино гэж МАХН-ын Төв Хорооны нэгдүгээр нарийн бичгийн дарга, БНМ АУ-ын Ардын Их Хурлын Тэргүүлэгчдийн дарга Ю. Цэдэнбалын өгсөн даалгаврыг нам, улс, олон нийт, ХАА-н байгууллагууд удирдлага болгон бүрэн хэрэгжүүлж хадланг чанар сайтайгаар богино хугацаанд бэлт-

гэж аж ахуй, түүний нэгж бүр хадлангийн төлөвлөгөөг давуулан биелүүлэхэд хамт олноосоо бүх анхаарал хүчийг чиглүүлэх ёстой.

Хадлан тэжээл бэлтгэх ариун үйлсэд 8 настай балчираас 80 настай буурлууд хүртэл иргэн бүр ариун хөдөлмөр хувь нэмрээ оруулах нь хадлан тэжээл бэлтгэх ажилд бүх нийтийн оролцуулах гэсэн манай намын гүн агуулгатай бодлогын биелэл болох билээ.

Хадлангийн төлөвлөгөөг сум, бригад, ферм хэсэг, суурь бүр 9 дүгээр сарын 1-нд давуулан биелүүлэхийн тулд уг ажлыг нягт нарийн зохион байгуулж оновчтойгоор удирдан хадланг богино хугацаанд чанар сайтай бэлтгэхийн учир холбогдолд иргэн бүрийн гүйцэтгэх үүрэг хариуцлагыг ойлгуулан ухамсарлуулж чадвал нам, засгаас дэвшүүлсэн зорилтыг сая биелүүлж чадна.

Хадлан тэжээл бэлтгэх бригад, хэсэг, суурь, айл өрх бүрийг намын гишүүд, сум, бригад, фермийн хариуцлагатай нарт хатуу хариуцуулан явцад нь хяналт тавьж байхын зэрэгцээгээр төлөвлөгөөгийн нь биелүлтэл нь туслацүүлэн тогтвортой ажиллуулж харилцаатай нь холбоон дүгнэх зарчмыг баримталж ажиллах хэрэгтэй. Хадлангийн төлөвлөгөөг тооны хуудад давуулан биелүүлэхийн зэрэгцээгээр өвсний чанарт гоц анхаарч чанарыг нь муутгахгүй байх нь чухал.

Боосон, тармасан өвсийг хураагчий талбай дээр байлгаж ус, хөрс- (Төгсгөл нь II нүүрт)

Аймгийн ХАА-н нэгдлүүдийг 1974 оны эхний хагас жилийн төлөвлөгөөт ажлын биелэлтээр байр эзлүүлсэн дүн

Нэгдлийн нэр	Эзлэх байр	Энхтуул	14
Хайрхан	1	Бүрэндэлгэрэх	15
Өрнөх-амьдрал	2	Туяа	16
Сүхбаатарын зам	3	Аймгийн ХАА-н нэгдлүүдийг 1974	
Авдархангай	4	оны эхний хагас жилийн ажлаар байр	
Хэрлэн-баян	5	эзлүүлэн дүгнэхэд Туяа, Энхтуул, Бү-	
Залуучуудын хөгжил	6	рэндэлгэрэх, Хөгжил, Шинэ-амьдрал	
Саруул-амьдрал	7	нэгдлүүд ажлаараа хоцорч яваад эрс	
Цацралт	8	дүгнэлт хийж, үлдэж байгаа хуга-	
Улаанбаатар	9	цаанд 1974 оны төлөвлөгөөт ажлын	
Хөдөлмөр	10	тасалдлыг бүрэн арилгаж ажлаа сайж-	
Заамар	11	руулахыг анхааруулж байна.	
Хөгжил	12		
Шинэ амьдрал	13	Аймгийн нэгдлийн зөвлөл	

АРАВ ХОНОГИЙН ӨМНӨ

СХ-ийн төлөө Батсүм-бэр сумын ХБА-ийн хамт олон бүх эрд түмний социалист уралдаан өрнүүлэн ажилласнаар 1974 оны эхний хагас жилийн ном, бараа, нийтийн хоол, талх үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 10 хоногийн өмнө 100—102 хувиар, түүхий эд бэлтгэлийн 42 нэртөрлийн зүйлийг 100—250 ху-

виар биелүүлж өр дутагдалгүй хамт олон болжээ. Одоо тус ангийн хамт олон МАХН-ын III их хурал болон БНМАУ-ыг тунхагласны 50 жилийн ой угтаж худалдаа бэлтгэлийн төлөвлөгөөт зорилтыг хугацаанаас нь өмнө биелүүлэхээр шамдаж байна.

Ц. ДАШ



ХАДЛАНЧДЫН БОЛЗОЛТ УРАМШИЛ

Хадлангийн биеэ даасан бригад, салааны механикжсан ажлын цалинг технологийн зураглалаар тооцон түүнийг 25 хувь нэмэгдүүлэн нийт бэлтгэх өвсний хэмжээнд хувааж, нэгжид олгох цалинг урьдчилан тодорхойлж болзолт тогтооно.

Уг ажил дуустал хийснээр нь буюу цагаар цалинжуулж хадлан авсаны дараа нэгжид олгох үнэлгээгээр бэлтгэсэн өвсний хэмжээг үржүүлж, олговол зохих бүх цалингийн хэмжээг гарган түүнээс урьдчилгаанд авсаныг хасч зөрүүг олгохыг болзолт урамшил гэнэ.

Хадлангийн ажилд болзолт урамшлын системийг зөв нэвтрүүлэхийн тулд юуны өмнө хадах талбайн га-гаас авах ургац, бригадын хэмжээгээр авах өвсний төлөвлөгөө, хадлан бэлтгэх ажлын дас дараалал (технологийг) тогтооно. Жишээ нь хадлангийн нэг механикжсан бригад, тракторч 15 туслах ажилчин 7, бүгд 22 хүний бүрэлдэхүүнтэй байхад 5000 тонн өвс бэлтгэх даалгавар өгч энэ ажлыг хийж дуусгах цалингийн фонд нь 13200 төгрөг байжээ гэвэл 25 хувийн нэмэгдэлтэй бүх цалингийн фонд нь 16500 төгрөг (13200×1,25) болно. Тэгвэл бэлтгэж нуруулдсан өвсний нэг тонн туулам олгох хөдсний үнэлгээ нь 3 төгрөг, 30 мөн (16500:5000) болох гэсэн үг юм.

Бэлтгэсэн өвсний хэмжээ ихсэх тутам авах хөдсний хэмжээ харьцангуй өснө.

Өвсийг нуруулдаж бэлэн болтол хүртлэх хугацаанд ажилчдад цалин олгож байх шаардлагатай.

Үүнийг олгохдоо ажилчдын өдөр тутам хийсэн ажил цагийг нарийн бүртгэж механикжсан ажилд ХЦХ-ний улсын хороо, МҮЭ-ийн Төв Зөвлөлийн 1970 оны 96/63 дугаар тогтоолоор батлагдсан норм үнэлгээгээр гар морин ажилд ХЦХ-ын хороо, МҮЭ-ийн Төв Зөвлөлийн 1965 оны 159-23-137 дугаар тогтоолоор батлагдсан норм үнэлгээгээр тус тус бодож хийсний хирээр нь урьдчилгааны журмаар цалин хөс олгоно. Хадлангийн ажлыг дуусахад бригадын ажлын гүйцэтгэлийг гаргаж нуруулдсан өвсийг САА, нэгдлээс томилогдсон комисс хэмжиж хүлээн авна.

Хүлээн авсан өвсний хэмжээг бэлтгэж нуруулдсан нэг тонн өвсөнд олгох хөдсний үнэлгээгээр үржүүлэн, жинхэнэ авсан бүтээгдэхүүнд өгөх бүх хөдсний фондыг тодорхойлно.

Хадлангийн бригад нь төлөвлөгөөгөө 0,5 хувиар давуулан биелүүлсэн бол 5025 тонн өвс (5000×100,5) авсан бөгөөд бэлтгэн нуруулдсан бүх өвсөнд олгох нийт хөдсний фондын хэмжээ 16582 төгрөг 50 мөнгө (5025×3,30) болно.

Д. ЛХАГВА

ХАДЛАНГИЙН АЖИЛ-БҮХ НИЙТИЙН ХЭРЭГ

Тогтоол. (Түрүүч нь
I пүүрт)

ний чийгэнд ялзуулж гэмтээх, зүй зохисгүйгээр үрэгдүүлж хохирол учруулдаг дутагдлыг гаргаж болохгүй. Өвс бэлтгэх технологийн шаардлагыг бүрэн хангаж өвсийг хаягдалгүй хураахад байгууллага, хүмүүсийн үүрэг хариуцлагыг өндөржүүлэх хэрэгтэй.

Хадлан бэлтгэх ажилд арвийн хэмнэлтийн хатуу зарчмыг тууштай нэвтрүүлж аж ахуйч бус явдалтай тэмцэж төсөвт зардалд багтаан хадлангийн төлөвлөгөөг биелүүлэх нь чухал. Өргөн айлсалтын давуу талыг ашиглан тэнд төлөрсөн олны хүчлийг үр ашгтай зөөвөр зохион байгуулан зоолой болон бусад төрлийн гар тээврийг их хэмжээгээр бэлтгүүдлэл зохино.

Төлөвлөгөөт хадланг хугацаанд нь чанар сайтай, технологийн шаардлагын дагуу бэлтгэх, тэргүүн туршлага дэвшилтэт арга ажиллагаа нэвтрүүлэх, үрэгдэл хаягдлыг арилгах, шатахуун, боолтын утас зэрэг материалыг санхүү мөнгөн хөрөнгийг

аль болохоор хэмнэхэд чиглүүлэн хадланчдын улс төр, хөдөлмөрийн идэвхийг өрнүүлэн социалыг уралдаанд бригад, салаа, хүн бүрийг хамруулан зохион байгуулж богино хугацаанд дүгнэж байх нь чухал. Даалгаварт хадлангаа хугацаанд үлгэр жишээч бэлтгэгсэд, зоолой болон бусад гар тээвэрийг чанар сайтай их хэмжээгээр бэлтгэсэн хүмүүсийг эд материал, боловсрол, суртал, хууны талаар байнга урамшуулж байвал зохино. Ялангуяа хадлангийн ажлын анхан шатны бүртгэл тооцоог нарийн хөтөлж хүн бүрийн хийсэн ажлын хөс цалинг тухай бүрт олгож байхыг хамт хоол хүнс, орон сууцны тохитой соёл ахуйнхаа нөхцөлөөр тухай байлгахад нэгдэл, САА бүр-ихээхэн анхаарах хэрэгтэй. Төрчилэн малдаа чанар сайтай хүрэлцэхүйц хэмжээний өвс тээвэл бэлтгэхийн улс төр, дийлэнц зогсонги ач холбогдлыг тайлбарлаж ойлгуулахад ухуулга соёл хүмүүжлийн ажлыг чиглүүлвэл зохино.

Н. ХАНДСҮРЭН



Саяхан Архустын сургууль комбинатыг автын жолооч 30 гаруй, тракторч-комбайнчийн мэргэжлээр 539 хүн төгсч мэргэжлийн үнэмлэх өвөрлөн эх орныхоо дөрвөн зүг найман зовхисыг зорин хөлгийн жолоо заллаа.

Тус сургуулийн хэмжээгээр 97,6 хувийн сурлагын амжилт үзүүлснээс трактор-комбайнч 18 анги, бүлэг 100 хувийн сурлагын амжилттай суралцсаны дотор багш Шаранхаан, Даржаа, Жүгдэр нарын даасан ангиуд анги танхим, байрны соёлжилт, сонсогчдын сахилга бат, сайн сурлагатны эзлэх хувийн жингээр сургуулийнхаа хэмжээнд түрүүнд явна.

Сонсогчдоо 12 дугаар группийн Зоригт, (Булганы) 5 дугаар группийн Шагжаахүү (Өмнөговийн) Баяраа (Төвийн), 10 дугаар группийн Мөнхтөр (Ховдын) нарын олон хүн сайн дүнтэй шалгагдав.

Д. ОТГОН

ТЭЭВЭРЧДИЙН ӨДӨРЛӨГ БОЛОВ

Өнгөрөгч Ням гаригт аймгийн ТУГ-ын өдөрлөг боллоо.

Өдөрлөгийг ТУГ-ын дарга Т. Сэр-Од нээж үг хэлсний дараа жолооч нарын гурван төрөлт тэмцээний ажиллагаа эхлэв.

Жолооч нарын онолын мэдлэг, уран жолоодлого, шалмаг зөв ажиллагааг шалгаруулах энэ сонирхолтой тэмцээнд 5 байгууллагын 20 жолооч оролцож мэргэжлийн уран чадвараа сорилцлоо.

Туг сүлжих, гараашид

тавих, наймын тоо эргэх, хаалгаар орох зэрэг арван бэрх дасгалыг уран жолоодлогоор богино хугацаанд зөрчилгүй хийсэн 6 жолоочийг шалгаруулан шалмаг зөв ажиллагааны тэмцээнд оруулж уралдуулахад ТУГ-ын жолооч С. Мягмар 1270 оноогоор нэгдүгээр байр Ц. Чулуунбаатар, Л. Баясдал нар удаах байруудад шалгарч улсын уран жолоодлогын уралдаанд оролцох эрх олж авав.

Өдөрлөгийн үеэр хур-

дан морьдын уралдаан болж их насанд ТУГ-ын жолооч Жамъянгийн хээр, морь, соёлолд Тэжээл фондын конторын ажилтан Санжаасүрэнгийн хүрэн халзан соёлод түрүүлж, үнэсний бөхийн барилдаанд ТУГ-ын тамирчин аймгийн заан Ш. Готов түрүүлж 8 жилийн дунд сургуулийн тамирчин аймгийн арслан Мөнхбат үзүүр булаацалдав.

Ш. ЦЭРЭНДОО

ХАДЛАНЧДЫН ДУНД ЗОХИОХ СОЁЛ ХҮМҮҮЖЛИЙН АЖИЛ

Мал аж ахуйн тогтвортой өсөлтийг хангах хамгийн гол нөхцөл нь малдаа арвин их тэжээл бэлтгэх үүний дотор байгалийн хадлан өвсийг сайн базааж авах явдал юм.

Бүх нийтийг хамардаг энэ чухал компанит ажил манай орон даяар өрчимтэй өрнөж байна.

Энэ онд манай аймаг хадлан 95,7 мянган тонн, таримал тэжээл 74,1 мянган тоннныг бэлтгэх болно. МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс 1973 онд гаргасан хадлан тэжээл бэлтгэх зарим арга хэмжээний тухай тогтоолыг удирдлага болгон аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас хадлан тэжээл бэлтгэх ажлын бэлтгэлийг хангах, зохион явуулах арга хэмжээний тухай тогтоол

хадланчдын дунд зохиох социалист уралдааныг өрнүүлэх журмын талаар Удирдамж гаргаад ажилдаж байна.

Хадланчдын дунд зохиох соёл хүмүүжлийн ажлыг сайн зохиосноор богино хугацаанд явагддаг хадлан тэжээл бэлтгэх ажлыг чанар сайтай гүйцэтгэхэд хадланчдыг идэвхжүүлэх онцгой ач холбогдолтой. Өнгөрсөн жилүүдийн туршлагаас үзэхэд Өндөрширээт, Жаргалант сумдын нам, захиргаа, олон нийтийн байгууллага хадланчдын дунд зохиох үзэл суртал, соёл хүмүүжлийн ажлыг чанартай зохион байгуулж амжилтанд хүрч байв.

Жаргалантын САА-н намын хороо хадланчдын дунд богино хугацаатай уралдааныг зарлан тогтоол дүгнэж, кино, кон-

церт, үзүүлэлт ухуулга, халуун ус, үсчин зэрэг олон төрлийн үйлчилгээг той трактор клубыг хадлангийн бригадуудын дунд тодорхой графикаар аядуулж үр дүнд хүрэв.

Иймд сумдын нам, захиргааны байгууллага хадлангийн бригадуудад сумын төвөөс сонин хэвлэлийг тогтмол хүргэж мал аж ахуйн бригадуудын ээлжит өдөрлөгийг хадлангийн бригадууд дээр төвлөрүүлэн хийж байвал зохино.

Хадланчдын ажлын өдөрт нь дүгнэж, тэргүүний ажиллагаатай хүмүүсийг урамшуулан шагнаж Баян-өнжүүл сумын туршлагаар төлөвлөгөөг чанартай биелүүлсэн хадланчдын ар гэрийн хүмүүст баяр хүргэх мөн хадлангийн хугацаанд олон удаа сайшагдсан

хүмүүсийг ажлын эцэст жич шалгаруулан байр эзлүүлж урамшуулах зэрэг социалист уралдаан байнга шагналын олон хэлбэрийг өргөн ашиглах нь чухал.

Улс, аймаг, сум, бригадын тэргүүний хадланчдын ажлын арга туршлагыг нэвтрүүлэхийн тулд хэвлэл радиог өргөн ашиглахын хамт хадлангийн бригадуудад нам, эвлэлийн хэсэг байгуулж тэдэнд хадланчдын дунд зохиох соёл хүмүүжлийн ажлыг хариуцуулвал зохино.

Хадлангийн ажлыг богино хугацаанд чанар сайтай бэлтгэх гол нөхцөл нь хадлангийн машин техникнийг бригад, салаадад зөв хуваарилан, өвсийг хадлах, тармах, бухалдах, нуруулах, боох, хураах техник багаж хэрэгслийн хэвийн ажиллагааг тогтмол хангаж, хөдөлмөр зохион байгуулалтыг сайж-

руулан хадланчин бүрт ажлын хуваарь норм, хэмжээг ойлгуулж хадлангийн ажлын явцыг байнга шалгаж туршлагыг дэлгэрүүлэн дутагдлыг тухай бүрт нь засуулж байх нь чухал.

Хадлангийн бригадуудад үйлчлэн туслах бригадыг хүн, мал эмнэлэг, клуб, номын сан, худалдаа үйлчилгээ, урлаг уран сайхны бүрэлдэхүүнтэй явуулж үйлчлэх хэрэгтэй.

Мал аж ахуйн өвлийн бэлтгэл ажлын хамгийн шийдвэрлэх хэсэг болсон хадлан тэжээл бэлтгэх ажилд бүх нийтийг татан оролцуулж хадланчдын дунд зохиох соёл хүмүүжлийн ажлыг тогтмолжуулан хадлангийн ажлыг өрчимжүүлэх явдал манай аймгийн нам, улс, олон нийт, ХАА-н байгууллагын гол зорилт болж байна.

Р. БАЯРСАЙХАН

КОММУНИЗМЫН ЭРНИЙ АЖАЛ

Баруун сибирийн шугам шиг шулууан ургасан нарсан ой, толин цэнхэр хоёр мянган нуур, түргэн урсгалт Тоболь гол энэ бүхэн Курган мужийг үзэмсэг төгөлдөр болгожээ.

Курган нутгийн хүмүүстэй уулзаж явахад зочломтгой, хөдөлмөрт дуртай нөхөрсөг зан чанартай болох нь харагдаж байлаа.

Курганд байх хугацаанд мужийн эрүүлийг хамгаалах газрын дарга Роккина Наталья Александровна, мужийн гүйцэтгэх хорооны соёл эрүүлийг хамгаалах ажил эрхэлсэн орлогч дарга Заматина Мария Андреевна нартай уулзаж мужийн эрүүлийг хамгаалах ажилтай танилцаж хэд хэдэн эмнэлгийн газраар орлоо.

Тус мужид 13000 гаруй ортой 112 орчим болонц ажилладаг ба тэдгээрт 1800 орчим их эмч, 10000 дунд мэргэжлийн хүн ажиллаж байгаа нь 10000 хүнд 17 их эмч эмнэлгийн 115,4 ор ноогдож байна. Район бүрт районы болон хэсгийн болонц гэж байдаг ба зарим үйлдвэрсэн том районд төвлөрсөн районы болонц гэж байдаг байна.

Эдгээр нь 185—200 ортой бөгөөд төвлөрсөн районы эмнэлэг 400—600 ортой, 13—30 төрлийн нарийн мэргэжлийн тусламж үзүүлдэг аж.

Мөн хүүхэд, эмэгтэйчүүдэд зөвлөлгөө өгөх газар, поликлиник, төрөх газар бүх газарт салбарласан байхаас гадна хүүхдийн болонц мужийн хэмжээгээр 2 байдгийн нэг нь 1 сар хүртэлх настай хүүхдийг хүлээн авч эмчилдэг байна.

Диспансерийн аргаар хүн амыг үйлчлэх явдал эмнэлгийн үндсэн зорилт болжээ. Үүнд эрүүл, эвчтэй хүүхдүүд, эмэгтэйчүүд, малчид, хөдөө аж ахуйн ажилчид механизаторууд,

үйлдвэрийн ажилчдыг диспансерийн хяналтанд байлгадаг байна.

Эмнэлгийн өндөр мэргэжлийн тусламжийг мужийн болонц тусгай мэргэжлийн диспансерууд гүйцэтгэж, хавдар-өмөн үү, сүрьеэ, арьс өнгөний диспансерууд ажиллаж байна.

Тус мужид анагаах ухааны 4 дунд сургууль, эмнэлгийн ухааны 14 нийгэмлэг, эмнэлгийн номын сан ажиллагдгийн гадна мужийн төвд мужийн нэг хоёрдугаар болонц, хотын нэг хоёрдугаар эмнэлэг, сэтгэл-эдрэлийн болонцод анагаах ухааны доктор нэг, дэд эрдэмтэн 5 ажиллаж байна. Курганд ЗХУ-ын хэмжээний ач холбогдол бүхий гэмтэл согогийг эмчлэх эрдэм шинжилгээний туршлагын институт ажилладаг.

КУРГАНЫ ЭРҮҮЛИЙГ ХАМГААЛАХ

Энэхүү институтыг анагаах ухааны доктор, РСФСР-ийн гавьяат их эмч Гаврил Абромович Илизаров толгойлдог ажээ.

Уг институтэд зөрсөн хагарал, хуурамч үе үүсч хэлбэр хэмжээ нь алдагдсан гэмтлүүд мэс заслаар эдгэрээгүй ясны идээлэлт (остеомиелит), засрал аваагүй янз бүрийн тохиолдол, төрөлхийн ясны янз бүрийн гажиг, дунд чөмөг шилбэний ясны богиносолт зэргийг тусгай аппаратаар сунгаж 3—4 долоо хоногийн дотор хэвийн байдалд нь оруулж байна.

Ясыг 38 см хүртэл сунгаж болж байгаа ба зөвхөн сунаад зогсохгүй зузаанаараа ч мөн адил төлждөг. Ер нь ямарч антибиотик хэрэглэхгүйгээр биологийн процесс идэвхжсэний үндсэн дээр ясны идээлэлт устаж эдгэрдэг

байна. Жирийн хугаралтай хүмүүсийг хоёр дахь өдрөөс нь босгож явуулдаг ба богино хугацаанд эмчилдэг.

Анагаах ухааны доктор, РСФСР-ийн гавьяат эмч Г.А. Илизаровын гайхамшигт энэ нээлтүүдээр Курганчууд бахардаг юм.

Бид энэ институт дээр очиж Г.А. Илизаровын уншсан лекцийг нь сонсож, яс сунгагч аппарат хэрэгсэл эмчилсэн өвчтөнийг нь мэдээрээ харж, ажил хийх байтугай гудамжинд алхаж гишгэж яваххаасаа гутаж гадагшаа гарч чаддаггүй байсан залуу эмэгтэй ямарч гажиг согоогүй гэв тэгшхэн хөлтэй болчихоод Курган мужид ирж сууршин өөрийн хөдөлмөрийнхөө дээжийг барина гэсэн өндөр сэтгэгдлээс нь сонсож дэлхийд гайхагдах суут нээлт Курганчуудад байгаагаар бахархах сэтгэл төрлө. Халдварт өвчинтэй тэмцэх түүнээс урьдчилан сэргийлэх талаар мужийн

вилагчдын 3 сарын мэргэжил дээшлүүлэх курс хийдэг байна.

Мөн эмч мэргэжилтнүүдийн дунд жил бүр «мэргэжлээрээ түрүүлэгчид» гэдэг конкурс явуулдгийн дээр бүх эмнэлгийн ажилчдын дунд коммунист хөдөлмөрийн хөдөлгөөн өрнүүлж коммунист хөдөлмөрийн хамт олон, коммунист хөдөлмөрийн гавшгайч хүндэт цол олгож тэргүүний хамт олон, хүмүүст шилжин явах улаан туг, дарцаг, диплом гардуулж байна.

Эмэгтэйчүүдийн зөвлөлгөө өгөх газраар ороход жирэмсэн эмэгтэйчүүдийг элдэв өвчнөөс урьдчилан сэргийлэх үзлэгийн кабинетууд, шинжилгээ, эмчилгээ, биеийн тамирын кабинет, өвдөлтгүй төрөхөд бэлтгэх кабинет, шинэ эх эцгүүдийн сургууль, эмнэлэг гэгээрийн сурталчилгааны кабинетууд ажиллаж бүх эмэгтэйчүүдэд резус үзэг стафилококкийн анатоксинийг 0,5 хувиар баруун далны дор эхчүүдэд цөмд нь 32 дахь долоо хоног 35—36 дахь долоо хоног, 38—39 дахь долоо хоногт нь тарьж нярайн халдвараас урьдчилан сэргийлдэг байна.

Хүүхдийн зөвлөлгөө өгөх газраар ороход нэг хэсэг, 1000 хүүхдэд үйлчилж үдээс өмнө 4 цаг үзлэг хийж үдээс хойш 3 цагийг гэрт дуудлагаар үйлчилж картыг нь төрсөн өдрөөр нь ялгаж дотор нь үсгийн дараалаар хадгалах юм.

Хүүхдийн картыг буцаалгүй эмч сувилагч дээр байлгаж гурвалжин хар цаас хавчуулж эдгэсэн үед нь хар цаасаа авч картанд явуулдаг.

Курганы эмнэлэгийн бүх мэргэжилтэн, ажилчид Төв аймгийн нийт эмнэлэгийн ажилтан ажилчдад ах дүүгийн халуун мэндчилгээ хүргэснийг сонин оор дамжуулан уламжилъя.

Курганд зочилсон хүний их эмч Н.ЛХАМАА

ЦСБ-д туслах хүчний
улсын зөвлөлгөөний өмнө

ТЭРГҮҮНИЙ БАЙЦААГЧИЙН НЭГ

НААУГ-ын ажилчин Банзрагч 1963 оноос галын орон тооны бус байцаагчийн ажлыг хийж энэ хугацаанд хариуцсан хороо, албан үйлдвэрийн объектын галын аюулаас урьдчилан сэргийлэх үзлэг, шалгалтыг байнга хийж, илэрсэн зөрчлийг тухайн үед нь, шаардлагатай зарим асуудлыг төв байгууллагад албан ёсоор мэдэгдэн засуулдаг байна.

Сүүлийн 5 жилд 218 удаа 3040 хүн цагийн шөнийн эргүүл шалгалтыг хийж 4954 хүнд галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар гаргасан тогтоол зааврыг ухуулгын төрөл бүрийн хэлбэрийг ашиглан сурталчлан таниулжээ.

Банзрагч гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх төрөл бүрийн үзүүлэн хийж, гал гарч болох объектын онцлог байдалд тохируулан тавьдаг ба галын сарайд байх багаж зэвсгийн загвар хийж ухуулгад хэрэглэж байна.

Тэрээр хариуцсан хороон дээрээ ЦСБТОН-ийн бригадын гишүүн Жамбаа, Базарсүрэн, Лувсанжамц нартай хамтран хууль сурталчлах булан байгуулж богино долгионы радио станцын өөрсдийн санаачилгаар хийж 10-аас доошгүй ухуулах самбар хийж объектын онцлогт нь тохируулан тавих, хууль дүрмийн сурталчилгаа ба эргүүл шалгалтын ажилд тооцоо нэвтрүүлэх зорилт тавин ажиллаж байна.

Иймээс Банзрагчийн хариуцсан албан үйлдвэрийн газар, хорооны айл өрхүүдэд сүүлийн жилүүдэд гал түймрийн ноцтой зөрчил гараагүй байна.

Ю. НЭРГҮЙ

РАШААН СУВИЛАЛЫНХАН

Жанчивлин дахь рашаан сувилалын дэргэдэх намын үүр (нарийн бичгийн дарга нь их эмч Цэвээн) амрагчдад хөнгөн шуурхай үйлчлэх, эмч сувилал, амрагч нартай нэг бүрчлэн ажиллахад гол анхаарлаа чиглүүлдэг байна.

Мэргэжлийн нийт сэхээт нүүдээр хувийн бүтээлч төлөвлөгөө хийлгээний гадна эмчилгээний тасгуудын хооронд уралдаан зарлан, хамт олон хүмүүсээс уралдаанд авсан амлалт, үүргийн биелэлтэнд байнга хяналт тавьж талсдаж болзошгүй зүйлд нь урьдчилан арга хэмжээ авч уралдааныг цуваагаар байр эзлүүлэн дунд нь сурталчилдаг байна. Мөн түүнчлэн хүн нэг бүрийн үүрэг хариуц-

лага, үйлчилгээний чанарыг сайжруулахын тулд даваа гаригт амралтын захиргаа, эмч мэргэжилтний ажил төрлийн зөвлөлгөөний хийлгэж, тэдний ажлыг дүгнэн зөвлөдөг байна. Тус амралтын газар сүүлийн 2 жилд 8400 гаруй амрагчдыг хүлээн авч, эмчлэн сувилж ачууруулсны 98,1 хувьд эмчилгээ нь бүрэн тохирч биеийн эрүүл мэнд нь эрс сайжирчээ. Ингэж рашаан сувилалын дэргэдэх намын байгууллагаас төлөвлөгөөт зорилтыг ханган биелүүлэх, үйлчилгээнд хөнгөн шуурхай боловсон байдлыг нэвтрүүлэх талаар системтэй ажил зохиосон нь үр дүнд хүрч байна.

Л. БЯМБАРИНЧИН



Аймгийн ХЗЭ-ийн байгууллагууд МХЗЭ-ийн анхан шатны байгууллагуудын нарийн бичгийн дарга нарын улсын зөвлөлгөөнд угтаж эвлэлийн дотоод ажлыг тогтмолжуулж үзэл суртал хүмүүжлийн ажлаа шинэ шатанд гаргах ажилчин малчин залуучуудын бүтээлч хөдөлмөрийг өрнүүлэхэд ажлаа чиглүүлэн зохиож байна. 1974 оныг «Залуучуудын гавшгай бүтээлийн он» болгоё гэсэн сэдвээр нийт гишүүд залуучуудын өргөтгөтгөсөн хурлыг ХЗЭ-ийн байгууллага

УЛСЫН ЗӨВЛӨЛГӨӨН УГТАЖ

бүр хийж, гишүүдээр үүрэг амлалт авахуулан биелэлт үр дүнг улирал бүр дүгнэж байна.

Аймгийн ХЗЭ-ийн хорооноос зарласан залуучуудын хэвлэлийн 50 жилийн ойн нэрэмжит төл бэйгуулах болзолт уралдаанд төлчин эвлэлийн гишүүд залуучуудыг идэвхтэй оролцуулах ажлыг нийт ХЗЭ-ийн байгууллагад амжилттай зохион байгуулжээ.

Энэ хугацаанд төлийн хорогдлыг өнгөрсөн онд хоос 2 хувиар багасгаж эвлэлийн гишүүд залуучууд нь хариуцсан малын төлөө 99,8 хувь бойжуулж байгаа Угтаалын САА-н ХЗЭ-ийн хороо тэргүүн байр эзэлжээ.

Мөн Говь-алтай аймгийн туршлагаар эмнэг морь, тэмээ уналга эдэлгээнд сургаж, ердийн хөсгийг өргөнөөр ашиглах зорилгоор сум бүрт эмнэг хангал сургаж секс байгуулан ажиллуулсны үр дүнд аймгийн эвлэлийн байгууллагуудын хэмжээгээр 1800 шахам эмнэг морь, тэмээ уналга эдэлгээнд сургажээ.

Баянжаргалан сумын залуучууд 180 гаруй морь 120 тэмээ сургаж, сургасан эмнэгээрээ бүтээлч ажлын цуваа гаргажээ. Түүнчлэн бүх бригадад ердийн хөсгийн баазыг 30—50 тэмээтэй тогтмол ажиллуулж байна.

А. МАНДАЛМАА



Чилийн цэргийн хунт зэвсгийн хүчээр ардын нэгдлийн засгийн газрыг түлхэн унагаасан (1973 оны 9 дүгээр сарын 11-ний өдөр) тэр цагаас тус орны коммунистууд, социалистууд, ардчилсан бүх хүчин, эх орончид, үйлдвэрчний эвлэлийн зүтгэлтнүүд ямар их хүнд харгислалд орсныг товч боловч дурдахгүйгээр Латин америкийн орнуудын ард түмний тэмцлийн тухай ярьж болохгүй билээ. Өнөөдөр Чилид, цэргийн хунтын фашист дэглэм ноёрхож, тус орны гэмгүй номхон иргэд төдийгүй Латин америкийн бусад орнуудаас Чилид амьдрагч улс төрийн дүрвэгсэд хүртэл хунтын харгислалд өртсөөр байна.

Чилийн хунтынхон төрийн эргэлт хийснээс хойш 30 гаруй мянган хүний амь насгүй бүрэлгэн 200 мянган ажилчдыг ажаллаж, үй олон оюутнуудын сурах эрхийг хасчээ. Эх орончид ардчилсан хүчний цусыг хунтынхон хичнээн урсгавч тус орны ажилчин анги ард түмэн, нууц байдалд байгаа хөдөлмөрчдийн нэгдмэл төвийнхөө удирдлагын дор тэмцлээ үргэлжлүүлсээр байна.

Латин Америкийн ард түмний тэмцэлд тус т-

вийн анхны социалист орон Куба улс үлгэр жишээ болж байна.

Хувьсгал ялснаас хойш 15 жилд Кубад ажилгүйдэл бүрмөсөн арилж, сургуулийн насны бүх хүүхдүүд сургуульд суралцаж, нутгийн хамгийн хоцрогдсон районд ч хүмүүс эмнэлгийн тусламж үзэж байна.

Тус оронд хувьсгал ялснаас хойш цахилгаан эрчим хүчний үйлдвэрлэл 3 дахин нэмэгдэж 1958 онд Куба 700000 тонн цемент үйлдвэрлэж байсан бол одоо 2300000 тонн үйлдвэрлэдэг болжээ.

Капитализмын үед Кубад загас агнуурын үйлдвэр огт байгаагүй бол одоо загас агнуурын үйлдвэрийн бүтээгдэхүүн 139600 тонн болжээ.

Латин Америкийн орнуудын ажилчин анги тооны хувьд улам өссөөр байна. 1960—1970 оны хооронд хөдөө аж ахуйн ажилчдын тоо 11 сая байснаа 13 болтол өсч, хотуудын худалдаа үйлчилгээний салбарын ажилчид 25—40 сая хүртэл нэмэгджээ.

Латин Америкийн монополист хөрөнгөтнүүд хөдөлмөрчдийн цалин хөлсийг бууруулан тэдний амьдралын нөхцөлийг улам доройтуулж байна.

Ийм учраас Латин Америкийн хөдөлмөрчдөөс империалистуудын эсрэг хийсэн тэмцэл өдрөөс өдөрт улам нэмэгдэж өр-

гөн далайцтай болсоор байна. Ганц баримтыг дурдахад сүүлийн 10 жилд энэ тэмцэлд 150 сая хөдөлмөрчид оролцожээ. Олон жилийн туршид хийсэн Аргентины хөдөлмөрчдийн шаргуу тэмцэл нь тус улсад цэргийн дэглэмийг устгаж үндсэн хуульд засгийг тогтооход хүргэсэн билээ.

Нефтийн баялгийг улсын болгох газрын шинэтгэл хийх, гадаад худалдаа болон эдийн засгийн гол салбаруудад хяналт тогтоох зэрэг Веласко Алварадогийн засгийн газраас авч байгаа арга хэмжээнүүдийг Перугийн ажилчин анги нийт хөдөлмөрчид дэмжиж байгаа юм.

Энэ оны 3 дугаар сард хуралдсан Перугийн хөдөлмөрчдийн бүх нийтийн холбооны 3 дугаар их хурлаас ажилчин анги, хөдөлмөрчдийн хөдөлгөөнийг улам бэхжүүлэхийг өөрийн орны ард түмэнд зуралжээ.

Перуд тус орны жинхэнэ тусгаар тогтнол олж, ард түмний аж байдалыг дээшлүүлэх талаар гарч байгаа нийгэм эдийн засгийн чухал өөрчлөлтийг тус их хурал нотлон харуулав.

Үндэсний эрх чөлөө, Панамын сувгийн талаар авч явуулж байгаа бодлогод ажилчин, олон түмний хөдөлгөөн чухал байр эзлэж байна. Эквадорын хөдөлмөрчдийн конфедераци нь

үйлдвэр, тээвэр, нефть боловсруулах заводуудыг улсын болгохын төлөө шийдвэртэй тэмцэл хийж байна. Хөдөлмөрчдийн үндэсний конветны эгнээнд нэгдсэн Уругвайн ажилчин анги сүүлийн жилд хэд хэдэн том бослого гаргасныг тус орны дэвшилтэт сэхээтнүүд, хүн амын дунд давхаргынхан оюутнууд өргөн дэмжжээ. 4,8 сая хүн амтай Пүэрто Рикон улсын 2 сая гаруй иргэд Америкийн нэгдсэн улсын хамгийн хавчигдмал байдалд амьдарч байгаа юм.

Тус улсын бүх хөдөлмөрчдийн гуравны нэг хувь нь үргэлж ажилгүй байдаг учир амьдрахын эрхэнд гадаадад үй олноороо гарч байна.

Пүэрто Рикон улсын эх орныхоо тусгаар тогтнолын төлөө тэмцэгч нэрт зүтгэлтэн Оскар Колясо, Лалита Леврон, Ирвинг Филос, Андрес Фигороа, Рафаел Миралда нар 20—24 жил АНУ-ын шоронд хоригдож байна.

Генерал Арана Осорлогийн засгийн газраас Гватемалын эх орончид, үйлдвэрчний зүтгэлтнүүдийг хавчин гадуурхаж байна.

Арана Осорлогийн засгийн газраас харгис үйл ажиллагаа явуулж буй боловч үнэнч шударга ёсны төлөө тус орны ажилчин анги, нийт хөдөлмөрчид тэмцсээр байна.

Д. ДУЛАМЖАВ

Багш нарын

Зөвлөлгөөний өмнө

Улсын болон аймгийн багш нарын зөвлөлгөөн устгаж Баянчандмань сумын 8 жилийн сургууль МАХН-ын Төв Хорооноос манай орны нам, улс, олон нийтийн байгууллагын ажилтан, ажилчид, эцэг эх, багш нарт илгээсэн захидалыг хэрэгжүүлэхэд ажлаа чиглүүлэн зохиож байна. Багш нарын мэргэжил боловсролыг дээшлүүлэх, багш нарыг шалгаруулалтанд бэлтгэхэд мэргэжил онолын бэлтгэл, орос хэл заах аргын ажилд биетэй дэмжлэг үзүүлж байна.

Тус сургууль багш нарт Улаанбаатар хотын 2 дугаар дунд сургуулийн зарим тэргүүний багш нарын хэрэглэж байгаа «тарааж өгөх материал», «Асуудал дэвшүүлэх арга», «Идэвхтэй минутыг нэмэгдүүлэх» аргыг эзэмшүүлэх зорилгоор арга, онолын маргаан, хүнд сэдэв заах аргын зөвлөлгөөний хийх зэргээр ажиллан багш бүрийг социалист уралдаанд тодорхой үүрэг авахуулжээ.

Эцэг эхэд сурган хүмүүжүүлэх сэдэвт хичээл 7 хоног бүр зааж, төвийн албан үйлдвэрийн газрууд анги бүлгүүдийг шөфлөн авч хүүхдийн хүмүүжилд туслах, ангиудын жижиг засвар ба парт сандалын урсгал сэлбэлтийг хийж өгдөг уламжлалтай болгожээ.

Г. САНЖААЖАМЦ

Ариун цэврийн сарын ажилд

САРЫН АЖЛЫН ГАРААНД

Орон даяар өрнөсөн ариун цэврийн сарын ажлын нэгэн жигүүр болж тус аймагт энэ ажил өрнөлттэй явагдаж эхлэв.

Ариун цэврийн сарын ажлыг эрхлэн явуулах аймгийн комиссоос гаргасан төлөвлөгөөний дагуу орон нутгийн салбар комиссууд ажилдаа орж эмнэлэг гэгээрлийн суртал ухуулга хийх, айл өрх, албан байгууллага, хороо, хоринор ариун цэврийн үзлэг явуулах цэвэрлэгээ хийлгэх зэрэг бүх нийтийг хамарсан далайцтай ажлууд зохиогдож байна.

Зуунмод хотын албан үйлдвэр, аж ахуйн газар, хороо хоринор ариун цэвэр соёлжилтын судалгаа авах эмнэлэг гэгээрлийн сурталчилгаа хийхээр аймгийн нэгдсэн больницын 20-иод их эмч, 80 шахам бага эмч, сувилагчид явж судалгаа авсаны дээр дээр 3000 гаруй хүнд ухуулга яриа хийлээ.

Дээрх үзлэг судалгаа явуулсан дүнгээс үзэхэд Ойн аж ахуй, БУК зэрэг зарим үйлдвэр аж ахуйн

газрууд энэ талаар төлөвлөсөн ажилгүй ариун цэврийн комисс байгуулаагүй дутагдал илрэв.

Зуунмод хотын 7 хорооны нутгийг хамарсан их цэвэрлэгээнд 660-аад өрхийн 1000 гаруй хүн оролцон хотынхоо гудамж талбай орчин тойрноо цэвэрлэв.

Цэвэрлэгээний дүнгээс үзэхэд Элдэв-Очир даргатай 2 дугаар, Алтангэрэл даргатай 5 дугаар хороод хүн хүчээ сайн зохион байгуулан богино цагт цэвэрлэгээг дуусгасан байна.

Дээрх хороодыг хариуцсан аймгийн нэгдсэн больницын Д. Сэмхээ даргатай хүүхдийн тасаг, П. Бумбага даргатай дотрын тасаг болон олон нийтийн ариун цэврийн байцаагч Уртнасан, Норжмоо нар эмнэлэг гэгээрлийн сурталчилгааг чанаржуулж хүмүүсийн хамрагдах хүрээг өргөжүүлснээр айл өрхийн ахуйн соёлжилт ариун цэвэр сайжран соёлч өрхийн тоо нэмэгдэв.

Саяхан явагдсан үзлэг-

гээр 5 дугаар хорооноос Онцоо, Жамъянсамбуу, Дагвадоржийн зэрэг олон айл ариун цэвэр соёлжилтоороо онцсайн шалгагджээ. Гэтэл нийтийн арта хэмжээ болгон явуулж байгаа энэ ажлын ач холбогдлыг дутуу үнэлж зохион байгуулсан ажилд муу оролцох, сурталчилгааг хэлбэрдэх зэрэг дутагдал Намхай даргатай 6 дугаар, Равжир даргатай 3 дугаар, Маналжаа даргатай 7 дугаар хороон дээр үзэгдэв.

Албан газар, хороо хорин ариун цэврийн байцаагч нар энэ ажилд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэж зохион байгуулалтын арга хэмжээг чанартай хийж төлөвлөгдсөн бүх ажлыг хугацаанд нь гүйцэтгэхэд чухалчлан анхаарвал зохино.

Эл дутагдалд дүгнэлт хийх бүх нийтийн арта хэмжээ болгон зохион явуулж байгаа ариун цэврийн сарын ажлын үеэр зохиогдох төрөл бүрийн хэлбэрийн ажилд айл өрх албан байгууллага бүр идэвхтэй оролцогоод.

Ш. ЦЭРЭНДОО

Эмчийн зөвлөлгөө

ШҮДНИЙ КАРИЕС ӨВЧИН

Кариес гэдэг бол шүдний хатуу эдийнцоролт юм. Энэ өвчин нь шүдний хатуу эдийг гэмтээгээд зогсохгүй хордолт харшлын гаралтай аргаа анги-на, хэрлэг, зүрх, бөөрний үрэвсэл, үе мөчний зэрэг олон төрлийн өвчнийг үүсгэгч голомт болдог.

Кариес өвчин нь хүүхдийн эрүүл мэндийн өөрчлөлт амны хөндийн эрүүл бус байдал, бодисын солилцооны хямралын үндсэн шинж тэмдэг юм.

Хүүхдийн шүд нь 6—7 сартайгаас эхлэн шүдлэг хоёроос хоёр хагас настайдаа 20 шүдтэй байх ёстой. Ялангуяа сүүн шүд, байнгын шүдээр солигдох үед кариес өвчнөөр өвчлөх явдал их тохиолддог.

Кариес өвчнөөс урьд-

чилан сэргийлэхэд хүүхдийг бүр багаас нь эхлэн амны хөндийн эрхтэнийг зөв арчлуулж сургах нь зүйтэй. Хүүхдийг ойндоо хүртэл заавал эхийн сүүнээр нь тэжээх, мөн уургаар баялаг бяслаг, сүү, цагаан идээ, мах, эрдэс бодис агуулсан хүнсний ногоо, жимс зэргийг өргөн хэрэглэх нь ашигтай.

Шүдний өвчнөөс урьдчилан сэргийлэх мөн эмчилгээний зориулалттай «Мэри Члери», «Помарин» Бальзам зэрэг онуудыг хэрэглэвэл зохино.

Сойзоор шүдээ цэвэрлэхдээ буйлнаас шүдний ирмэг рүү, гадаргуун дагуу гадна дотногүй сойз доно. Угаасан хуруугаараа оог тарааж буйланд илгээ хийх нь маш сайн.

Их эмч Ц. САНЖААЖАМЦ

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д. ТОВУУ

Зарлал

Баяндэлгэр сумын харьяат Содном овогтой Цэдмаа нь 10 дугаар анги төгссөний 1586 тоот аттестатаа үрэгдүүлсэн тул хүчингүйд тооцов.